



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНМӨНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/19

Улаан эрэг

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын мэргэжлийн ангийн бүлгүүдэд шаардлагатай багаж тоног төхөөрөмж худалдан авах зардалд 7,000,000 (долоон сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2.Зардалд шаардагдах 7,000,000 (долоон сая) төгрөгийг Гамшгийн эрсдлийн сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Н.Батаа)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (А.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.Нямдаваа О.НЯМДАВАА

